

дасгал, бодит тохиолдол, кейс дээр оюутнуудыг багт хувааж ажиллуулах, өөр хооронд нь мэтгэлцүүлэх, асуудал хэлэлцүүлэх аргыг хэрэглэх боломжтой.

Иргэний хэргийг хянан хэлэлцээд шүүхээс гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, магадлал, түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс гаргасан иргэний нэхэмжлэл, эрх зүйн баримт бичгийг тарааж судлуулах, иргэний шүүх хуралдааны видео бичлэгийг үзүүлэх зэрэг нь Клиник сургалтын загварчлалын аргад хамаарна.

Иргэний хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн дүрд тоглуулах арга замаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг явуулах үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөх ур чадварыг оюутанд зохих хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой.

Эцэст нь дүгнэж авч үзвэл хууль зүйн клиник сургалт бол бодит үйлдлээр дамжуулан хуульчийн мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх, суралцагчийг аливаа асуудалд шурган оруулах, хийнгээ суралцах, ярилцангaa суралцах зарчим дээр тулгуурласан сургалтын хамгийн оновчтой хэлбэр юм.



Г.НАРАНБАЯР

*Дорноговь аймгийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
албаны шийдвэр
гүйцэтгэгч*

ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ.

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил, уламжлал

Монголчууд газар нутагтаа төрөө үүсгэн байгуулж, хууль цаазыг зохиож ирсэн эртний сонгодог уламжлалтай хэмээн судлаачид нэг бус удаа тэмдэглэсэн нь бий. Эртний хууль цаазын сурвалж бичгүүдэд эрх зүйн салбараар нь системчлээгүй харин нэгэн цааз бичигт нэгтгэн бичиж зохицуулж байсан.

Гэр бүлийн харилцааг зохицуулсан бие даасан эрх зүйн акт байгаагүй нь гэр бүлийн эрх зүйгээр зохицуулах нийгмийн харилцаа байгаагүй гэсэн үг биш. Ийм харилцаа түүхийн аль ч үед байсан. Түүнийг төрийн цааз бичиг болон заншлын хэм хэмжээгээр давхар зохицуулж байсан нь илт юм. **Их засаг хууль³⁶** бол Монголын феодалын нийгмийн харилцаа, төрт ёсны үеийн гол хууль бөгөөд эзэн Чингисийн үеэс зарлиг, тогтоол, ихэс дээдсийн үүрэг, даалгаврын хэлбэрээр гарч ирсэн хэм хэмжээнүүдийг нэгтгэн эмхтгэж төрийн гол хууль болгон тунхагласан байна. Энэ хуульд гэр бүлийн харилцаа тэр дундаа гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг хэрхэн зохицуулж байсныг тоймлон үзвэл: Олон эхнэртэй

³⁶ С.Жаалан-Аажав “Халх журам Монголд улсын хууль цаазын эртний дурсгалт бичиг”, УБ, 1985, 15 тал

байхыг хүлээн зөвшөөрч, хэрэв олон эхнэртэй тохиолдолд тэдний дотроос анхны эхнэр нь бусдыгаа ахлана. Мөн түүнчлэн татвар эхнэрээс гарсан хүүхдэд гэр бүлийн эд хөрөнгөөс хувь өгч байсан.

Юань улсын хувьд гэр бүлийн харилцааг урьд оршин байсан Сүн, Алтан улсын хуулийн үзэл баримтлал хийгээд Хятадын зан заншлын уламжлалд тулгуурлан тогтоожээ.

Энд тэмдэглэснээр гэрлэгчид гэрлэлтийн гэрээ хийх ёстой бөгөөд гэрээ нь хүүгийн эцэг, хэрэв эцэг нь нас барсан бол эхээс зөвшөөрөл авч байж сая хүчин төгөлдөр болж гэрлэх эрхтэй байна.

Хэрэв гэрлэлтийн гэрээнд тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр гэрлэх ёслолоо хийгээгүй болон завхайрсан этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ тус тус хүчингүй болно гэж заажээ.³⁷

➤ **1640 оны Монгол – Ойрадын хуулиар** Монгол – Ойрадын ноёдын дундах эвдрэлийг зохицуулах, эрүү, иргэн, засаг захиргааны харилцааг зохицуулж байсан. Гэр бүлийн харилцааг хэрхэн зохицуулсан талаар цухас үзвэл: Энэ үед гэрлэлтийг дэмжиж байсан нь хуулийн зохицуулалтаас харагддаг бөгөөд энэ нь цэрэг эрчүүдийг бэлтгэхтэй холбоотой байсан болов уу. Тухайлбал 40 өрхөөс жил бүр 3 хөвгүүнийг гэрлүүлж байх, 10 хамжиж тэдгээрийг гэрлэхэд тусалж байх хэм хэмжээг хуульд тусгасан байна.

Халх журам бол Монголын өөрийн жинхэнэ ахуй амьдралаас ургуулан Монгол сэтгэлгээгээр зохиож эх орны тусгаар тогтол, эдийн засаг, төрт ёс, шашин шүтлэг, зан заншлаа хуульчлан баталгаажуулж байсныг гэрчлэх эрх зүйн

гайхамшигт баримт бичиг болно. Энэхүү түүхэн баримт бичигт гэр бүлийн талаар тусгасан байдлыг үзвэл: энэ хуульд заасан гэр бүлийн зохицуулалтыг хараад нь хүн нөхөрт гарахад нь хаад ноёдын охид нь өндөр инж, сүй бэлэгтэй, харин харцын охинд бол “бага” байх зарчимтай байжээ.

Ноёд тавнангудын охиныг гүйваас мөнгөн аяга, сувд, архи хүрвээс тооцно. Үгүй бөгөөс тооцохгүй. Бас харц хүн өөр зуураа сүйлэх аваас архи болоод хонины гэдэс дотор, эвэр туурай гүйцэд болбоос тооцох гэх зэргээр заасан нь гэрлэхэд эрэгтэй, эмэгтэй хоёрын бие биээ хайрлах нь гол биш сүйд өгсөн эд хөрөнгө гэрлэх хэмжигдэхүүн болдог байсан.

Хүний жам ёсны эрхийн нэг өмчлөх эрхийн харилцааг мөн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Иргэний хуулийг 1926 онд батлан гаргасан³⁸. уг хуулийн тавдугаар бүлэг нэг дүгээр анги “Аливаа хөрөнгө хогшлын тухай”-д дундын өмчийн тухайд зохицуулж өгсөн.

Уг хуулийн 95 дугаар зүйлд “Аливаа хүний хууль, дүрмийн ёсоор хураасан элдэв хөрөнгө хогшлыг түүний хувийн өмч хэмээвээс зохимой” гэж заасан ба уг хуульд хөрөнгийг хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө гэж зааглан заасан ба тэдгээрт хамаарах хөрөнгийг тусгаарлаж өгсөн.

1926 оны Иргэний хуульд дундын өмчийн талаар анх зохицуулж өгснөөр түүхэн ач холбогдолтой бөгөөд түүний зарим зүйл, заалт нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн байна.

1952 оны Иргэний хуульд дундын өмчийн тухай “өмчлөх эрхийг нэг ба хамтын

³⁷ З.Сүхбаатар, П.Оюундэлгэр, “Монгол Улсын Иргэний хуулиуд нэмэлт өөрчлөлтүүд”, УБ, 2002, 37 тал

³⁸ Монгол улсын түүх /дэд дэвтэр/, УБ, 2003, 109 тал

бүхий хоёр буюу хэд хэдэн хүн нийтээр эдэлж болно” гэж заажээ.

1960 онд шинэ Үндсэн хууль батлагдаж Монгол улсын Социалист чиг баримжаагаар хөгжүүлэх үндсийг тавьсан.

Үүнтэй холбоотойгоор БНМАУ-ын Ардын их хурлаас 1963 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шинэ Иргэний хууль батласан билээ. Уг хуулийн хоёрдугаар хэсэг нэг дүгээр бүлэгт өмчийн эрхийн талаар хуульчилж өгсөн бөгөөд “...БНМАУ-ын иргэн бүхэн социалист өмчийг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж, бүх талаар арвижуулан бэхжүүлэх үүрэгтэй” гэж заасан байна.

Уг хуулийн 6 дугаар бүлэгт дундын өмчийн талаар тухайлан бүлэг болгон хуульчилсан бөгөөд 76 дугаар зүйлд “...эд хөрөнгө нь хоёр буюу хэд хэдэн хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, олон нийтийн бусад байгууллагын хооронд мөн нэг буюу буюу хэд хэдэн хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, олон нийтийн бусад байгууллага ба улсын хооронд эсхүл хэд хэдэн иргэдийн хооронд дундын өмч байж болно” гэж хуульчилсан.

Мөн зүйлд дундын өмч нь хэсгээр өмчлөх дундын өмч, хамтран өмчлөх дундын өмч гэсэн хэлбэртэй байхаар зааж өгсөн.

Уг хуулийн 83 дугаар зүйлд “...гэр бүлийн эд хөрөнгө, хөдөө аж ахуйн нэгдлийн өрхийн эд хөрөнгө, нэгдэлжээгүй өрхийн эд хөрөнгө болон хуульд заасан бол бусад эд хөрөнгө хамтран өмчлөх дундын өмчид байна” гэж заасан байна. Уг хуульд 1990 онд өөрчлөлт орсон бөгөөд уг өөрчлөлтөд хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д “...өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах

эрхтэй” гэж заасан нь хүний өмчлөх эрхийг жинхэнэ утгаар нь хүлээн зөвшөөрсөн.

1994 оны шинэчлэгдэн найруулагдсан Иргэний хуулийн 65 дугаар зүйлд/ эд хөрөнгийг дундаа өмчлөх/ “...хоёр буюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болно”, мөн “дундаа хамтран өмчлөх эрхийг гэр бүлийн гишүүдэд олгохоор”, дундаа өмчилж байгаа этгээдүүд хамтран үүрэг хүлээх бөгөөд хөрөнгө тэнцүү хэмжээгээр өмчилнө” гэж зааж өгсөн.

Иргэний хуулийн 74 дүгээр зүйлд “...Монгол улсад хувийн, нийтийн өмч байна. Төр өмчийн бүх төрөл, хэлбэр чөлөөтэй хөгжих нөхцлийг бүрдүүлж тэдгээрийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д “...хоёр буюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болох ба тэдгээр нь өмчлөх эрхээ бие даан хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан.

1994 оны Иргэний хуулийг ардчилсан Үндсэн хуультай нийцүүлэхийн тулд 2002 онд шинэчилэн найруулсан байна.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн талаархи зарим орныхтой харьцуулан үзсэн байдал

БНХАУ-ын шинэчлэн нийтлэсэн Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “**БНХАУ-ын социалист нийгмийн өмч болон хувийн өмч**” гэсэн хэлбэртэй байхаар заасан байна.

Монгол улсын Иргэний хуулийн 108 дугаар зүйл, БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 78 дугаар зүйлд дундын өмчийн талаар тус тус зохицуулжээ.

Бүгд Найрамдах Япон Улсын Иргэний хуулийн 725-885³⁹ заалт нь гэр

³⁹ Япон Улсын Иргэний хууль, 2004

бүлийн эрх зүйтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Дундын өмчийн хувьд хувийн болон хамтын гэсэн хоёр хэлбэртэй байна гэж заасан.

Япон улсын гэр бүлийн тухай хууль нь манай улсынхаас нилээд онцлогтой байх бөгөөд үүнийг товч үзвэл⁴⁰: Эд хөрөнгийн хэлцэл хийх эрх зүйн чадамж нь 20 нааснаас эхлэнэ. Гэр бүл болох эрх зүйн чадамж нь эрэгтэй 18 нас, эмэгтэй 16 нааснаас үүснэ. Гэрлэгчдийн үндсэн эрх үүрэг нь хамтран амьдрах, хамтран хөдөлмөрлөх, харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх, гэр бүлийн үнэнч байдлыг хадгалах, нэг овогтой байх, эхнэр, нөхөр олсон орлого эд хөрөнгөөрөө гэр бүлд гарсан зардлыг тэнцүү хариуцах мөн гэр бүлийн тэжээн тэтгэх, гэрлэлтийн гэрээ, дундын эд хөрөнгөтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг гэр бүлийн шүүх байдаг.

Мөн БНЯУ-ын Гэр бүлийн тухай хуулийн нэгэн өвөрмөц зохицуулалт нь сүйлэх журам тогтоосон явдал юм. Сүй тавихдаа гэрээ байгуулдаг. Сүйлэх нь харилцан бэлэг солилцох замаар явагдах бөгөөд сүйг сүмд үйлдэхгүй байж болно. Сүйн гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээний нэг тал нөгөө талаасаа гэрээг албадан биелүүлэхийг шаардаж болохгүй. Гэхдээ ийнхүү зөрчсөн нь нөгөө талд бодитой хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай тал нь нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

ОХУ гэрлэлтийн гэрээний эрх зүйн зохицуулатыг 1995 онд батласан гэр бүлийн хуульдаа суулгаж өгсөн⁴¹.

Уг хуульд хэрхэн зохицуулсныг тоймлон үзүүлвэл: гэрлэлтийн гэрээ гэдэг нь

гэр бүл болох гэж буй этгээдүүд эсхүл эхнэр нөхрийн гэр бүл болсон хойноо болон мөн гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд эд хөрөнгийн хувьд эдлэх эрх, хүлээх үүргийг харилцан тохиролцох замаар байгуулсан хэлэлцээ байна гэж заасан.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик

2011 онд гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн нийт хэргийн 81,8 хувийг гэрлэлт цуцлахтай холбоотой маргаан эзэлж байгаа нь 2008 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 6,8 хувиар буюу нэг жилд 2,2 хувиар өсөж байгаа нь хүн бүрд гэр бүлийн баталгаа/ холбоо/ юунд оршиж байна вэ? гэсэн бодлыг өөрийн эрхгүй төрүүлэх буй за. Улсын хэмжээнд 1993 оноос хойш шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоог үзүүлэлтийг авч үзвэл⁴²: Хүснэгт 1

Гэрлэлт цуцлахад хамгийн маргаантай гэрлэгчдийн хувьд тэр бүр амархан тохиролкоонд хүрч чаддаггүй асуудал бол гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой харилцаа байдаг.

Гэр бүлийн тухай хуулийн зорилт нь... гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа..-г зохицуулахад оршино” гэж заажээ.

Гэвч гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг “Иргэний хуулиар зохицуулна” гэж Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан бөгөөд 2002 оны Монгол улсын Иргэний хуулиар бүхэлдээ буюу есөн зүйлд гэр бүлийн хөрөнгийн харилцааг зохицуулж байна.

⁴⁰ “Семейный кодекс РФ”, М, 2005, глава

⁴¹ www.maik.ru

⁴² Улсын дээд шүүхийн судалгааны төвийн судалгаа, 2003-2012 оны эхний хагас

Энэ нь Гэр бүлийн тухай хууль зорилтоо бүрэн биелүүлж чадахгүй байгаа гэдгийг харуулж байна.

2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл шийдвэрлэсэн 15610⁴³ иргэний хэргийн 1833 буюу 11,7 хувь нь гэрлэлт цуцлахтай холбоотой маргаан байна.

Гэрлэлт цуцлахдаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болон хуваарьт эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн нь тодорхой бус байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд гэр бүлийн дундын эд хөрөнгийн талаар эрт дээр үеэс хуульчлан ирсэн боловч гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн судалгаа байхгүй байгаа нь ихэвчлэн зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагддаг харилцаа болох нь харагдаж байна.

Өнөөгийн нийгмийн хөгжлийн түвшинг дагаад гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч байгаа тул цаашид энэ сэдвээр илүү их судалж эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх тал дээр хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.

⁴³ Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс авсан шүүхийн шийдвэрүүд

Хүснэгт 1

№	Он	Нийт шийдвэрлэсэн Иргэний хэрэг	Нийт шийдвэрлэсэн гэр бүлийн маргаан	Үүнэс			
				Гэрлэлт цушиасан	Эцэг, эх байх эрхийг хассан	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	Тэтгэлэг тогтоосон хүүхдийн тоо
1	1993	14864	2782				
2	1994	15734	2101				
3	1995	18939	1996				
4	1996	26437	2504				
5	1997	26936	2410				
6	1998	28107	2485	1637	1		1427
7	1999	28039	2191	1425	9		709
8	2000	21717	2192	1517	8		899
9	2001	23252	2412	1657	7		1371
10	2002	24100	2630	1799	2		1089
11	2003	23407	2777	1890	7	423	1556
12	2004	23290	2939	2004	3	442	1270
13	2005	24492	2955	2094	3	397	1437
14	2006	27469	2989	2237	12	342	1308
15	2007	30699	3544	1323	4	189	736
16	2008	24480	3629	2703	12	436	1213
17	2009	35822	4294	3295	16	414	1069
18	2010	35787	4732	3852	6	354	2079
19	2011	30368	4449	3642	7	364	1932
20	2012 эхний хагас		1833	1487	3	154	366